

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 17/457

ШУС, НУС

2016

**ОРЧИН ҮЕИЙН ДУНДАД УЛСЫН МОНГОЛ СОНИН СЭТГҮҮЛИЙН
ХӨГЖЛИЙН БАЙДАЛ ХИЙГЭЭД ОНЦЛОГ**

Оюун*

* Өвөр Монголын их сургуулийн профессор

Түлхүүр үг: монгол сонин сэтгүүл, шүүмж өгүүлэл, улс төрийн шүүмж өгүүлэл, улс төрийн өгүүлэл, соён гэгээрүүлэх, хорголжин бар, чулуун дармал, тосон дармал

Эхлэл

Монголчууд бол өн удаан соёл түүхтэй үндэстэн юм. Монгол сонин сэтгүүл бол монгол үндэстний түүх ба соёлын чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Монгол сонин сэтгүүлд авч үзвэл найдвартай материал баримт бүхий анхны сонин юм. Орос нутагтай буриад хүн Бадмаев 1895 онд Оросын Чита хотод эрхэлсэн “Дорнод хязгаарын амьдрал” (зарим эрдэмтэд 1860 он ба 1862 онд Буриадад “Амар” ба “Хиагт” гэсэн сонин гарч байлаа гэж үзэж байна)-аас үзвэл монгол сонин сэтгүүл нэгэнтээ 121 жилийн хөгжлийн түүхтэй болж байна. Харчин баруун хошууны Засаг жүн ван Гүнсээноровын 1905 онд эрхэлсэн “Гарагийн албан сэтгүүл” болон “Нялх сэтгүүл” бол Дундад улсын анхны монгол сонин болно. 1905-1949 онд Бүгд Найрамдах Дундад ард улс байгуулагдах хүртэл 44 жилийн хооронд дундад улсын хил дотор нийт

131 монгол сонин сэтгүүл хэвлэгдэж өнгөрчээ. Харамсалтай нь эдгээр сонин сэтгүүлүүдээс бидний үед зөвхөн 87 нь тархай бутархайгаар хадгалагдаж буй бөгөөд бусад нь хэвлэгдэж байсан мэдээ төдийхнөөр хязгаарлагдаж буй юм. Үүнд орчин үеийн Дундад улсын сонин сэтгүүлүүд засгийн газрын хууль зарлиг, хөтөлбөр ба шийдвэрийг уламжлан дэлгэрүүлэх эл зүйлийн улс төрийн хүчний ашиг тусыг хамгаалахад яриа хэлэлцээр зохиохоос гадна монголчуудад шинэ мэдлэг уламжлан тэдний соён гэгээрүүлэхэд зохих үүрэг гүйцэтгэсэн юм. Тэрчлэн сонин сэтгүүл нь нийгэм амьдралын тусгалын хувьд тухайн цаг үеийн чухал хэрэг учрууд зохих хэмжээнд тусгагдаж байдаг. Иймээс энэ их онцгой цаг үед гарч байсан монгол сонин сэтгүүлийн үг материалыг эмхэтгэн цуглуулж судлан шинжилж, онцлог шинжийг тодруулан гаргах нь бидний чухал үүрэг болж байна.

1. Монгол сонин, сэтгүүлийн тойм байдал

Харчин баруун хошууны Засаг жүн ван Гүнсээноров 1905 онд ваны ордондоо “Гарагийн албан сэтгүүл”

болон "Нялх сэтгүүл" хэмээх сониныг эрхэлж байв. 1908 онд Гириний Монголын явдлыг шийдэх газрын эрхэлж байсан "Монгол үгийн бодорол" бол Дундад улсын албанаас эрхэлсэн анхдагч монгол сэтгүүл болно. Үүний дараа 1909 онд хаант Орос Монголд явуулах үзэл бодлогоо идэхвжүүлэхийн тулд "Монголын сонин бичиг"-ийг эрхэлжээ.

Дундад иргэн улсын Бээжингийн засгийн газар 1912 онд "Ихэд нийтлэх монгол бичгийн сэтгүүл", 1913 онд "Монгол ер үгийн сэтгүүл", 1915 онд "Монгол утгын сэтгүүл", 1920 онд "Шо Фаны өдрийн сэтгүүл", 1925 онд "Монгол үсгийн нэгэн эргэлтийн хэвлэл", "Хол дахиныг амаржуулсан хотны долоон өдөр бүр дармаллах сэтгүүл" эрхэлж, Ар Монголын тусгаар тогтнолыг эсэргүүцэх, таван угсаа хамт найралдах үзэл буюу улс гүрний үзлийг ухуулж хятад үндэстний сургаалаар монгол хошуудыг нэгдүүлж, монголчуудын үндэстний ухамсрыг устган тэдний дотогш хандуулахыг зорьж байжээ. Мөн 1918 онд япончууд Мүгдэн хотод "Мүгдэний монгол сэтгүүл" эрхэлж, Монгол орныг түрэмгийлэх зорилгоор яриа хэлэлцээр зохиосон юм. 1925 онд Дотоод Монголын ардын хувьсгалт нам байгуулагдаж өөрийн байгууллагын сэтгүүл болох "Дотоод Монголын ардын сэтгүүл"-ийг эрхэлж, тус намын баримталж байгаа үзэл

баримтлалаа ухуулж байсан юм. 1926 онд Бүхэгхишэгийн үүсгэн байгуулсан Монгол утгын сургаалын хурал нь "Улаан бар" сэтгүүлийг эрхэлж, монгол утга, соёлыг ахиулан хөгжүүлэхэд нэмэр болж байв.

Дундад иргэн улсын Нанжин засгийн газрын Монгол-Төвдийн хэрэг явдлыг шийдэх газраас 1929 онд "Монгол-Төвдийн долоон өдрийн сэтгүүл", 1931 онд "Монгол-Төвдийн арван өдрийн сэтгүүл", 1933 онд үелэх хугацааг уртасгаж, "Монгол-Төвдийн хагас сарын сэтгүүл" хэмээн гаргаж байснаа 1934 онд үелэх хугацааг дахин уртасгаж, "Монгол Төвдийн сарын сэтгүүл" хэмээн гаргах болжээ. 1931 онд "Монгол утгын долоон өдрийн дармал"-ыг

гаргаж байжээ. Гоминданы төвийн уламжлан дэлгэрүүлэх Вэй Йовэний хурал 1931 онд Монгол-Төвдийн хэрэг явдлыг шийтгэх хурлын эрхэлж байсан "Монгол-Төвдийн долоон өдрийн сэтгүүл"-ийг дахин эрхэлжээ. Төд удалгүй "Монгол-Төвдийн арван өдрийн сэтгүүл", 1941 онд "Монгол-Төвдийн сарын сэтгүүл" хэмээн тус тус гаргаж байжээ. Монголын чуулган хошуудын холбоо нэгдэж нийслэлд цуглаж хэрэг шийдэх газар 1930 онд "Монголын арван өдрийн дармал", сүүлдээ хугацааг богиносгож "Монголын долоон өдрийн дармал" гэдэг сэтгүүлийг эрхэлж байжээ. Үүнээс гадна зүүн хойд

«

1908 онд Гириний Монголын явдлыг шийдэх газрын эрхэлж байсан "Монгол үгийн бодорол" бол Дундад улсын албанаас эрхэлсэн анхдагч монгол сэтгүүл болно. Үүний дараа 1909 онд хаант Орос Монголд явуулах үзэл бодлогоо идэхвжүүлэхийн тулд "Монголын сонин бичиг"-ийг эрхэлжээ

»

хэсгийн засгийн хэрэг шийдэх Вэй Йовэний хурал 1929 онд монгол хошуунд тараах арван өдрийн дармалыг эрхэлж, Сүй Йовэн мужаас 1929, 1933, 1935, 1939, 1947 онд тус тус Сүй Йовэний “Монгол үсгийн хагас сарын дармал”, “Монгол утгын долоон өдрийн сэтгүүл”, “Монголын газарч”, “Зах хязгаарын чимээ нэвтрүүлэх сэтгүүл”, “Шинэ монгол” зэрэг сонин сэтгүүлийг эрхэлж байжээ. Цахар мужаас 1947 онд мөн “Монголын дуу” хэмээх сэтгүүлийг эрхэлж байжээ. Эдгээр сонин сэтгүүлүүд цөм голдуу Сүнжуншайн ардын гурван зорилтыг ухуулж Нанжины засгийн газрын Монгол-Төвд оронд авч байгаа төрийн бодлогыг уламжилж Монголын нийгэм, улс төр аж ахуй, шашин, зэрэг сурган хүмүүжил талын асуудлуудыг шүүмжлэн өгүүлж байсан юм.

Монгол оюутнууд мөн монголчуудын ухаан мэдлэгийг нээж, Монголоо мандуулан хөгжүүлэхийг гол зорилт болгож монгол сэтгүүл эрхэлж байсан юм. Үүнд Бэйпинд байх монгол сурагчдын хурлын 1929 оноос эхлэн эрхэлсэн “Монгол”, Нанжины Монгол-Төвдийн сургуулийн монгол сурагчдын 1933 онд эрхэлсэн “Ирээдүйн монгол”, зүүн хойд монгол хошуудын багшийн сургуулийн сурагчдын 1930 онд эрхэлсэн “Зүүн хойд монгол хошуудын багшийн сургуулийн дармал”, Ниппонд байсан монголчуудын хурлын 1930, 1935, 1941 онд тус тус эрхэлсэн “Эх орон”, “Манханы хонх”, “Шинэ Монгол” зэргийг дурдаж болно.

1932 онд Манж-Го улс байгуулагдсаны дараа тус улсын Хянган ерөнхий балгад 1933 онд “Хянган ерөнхий балгадын хураангуй дармал”, монгол

засгийн жуурган 1934 онд “Монгол засгийн жуурганы хураангуй дармал”, “Монгол” сэтгүүлүүдийг эрхэлж байжээ. Монгол хурлын гэр 1937 онд “Монгол шинэ сэтгүүл”, 1938 онд “Хүүхдийн шинэ сэтгүүл”, “Залуусын толь” гэх сэтгүүлүүдийг тус тус эрхэлжээ. Хөх туг сэтгүүлийн хоршоо 1941 онд “Хөх туг” хэмээх сонин гаргаж байв. Манж-Го улсын эдгээр сонин сэтгүүлүүд нь засгийн зарлалыг уламжлах монгол үндэстний соёлын хөгжил, ард иргэдийн боловсролыг дээшлүүлэх, Японы үзэл баримтлалыг сурталчлах талаар үүрэг гүйцэтгэж байсан юм.

Дэмчигдоноровын Монголын хязгаарын засгийн гадаад явдлын газар Монгол хязгаарын шинэ сэтгүүлийн хороо 1938 онд “Засгийн ордны албан сэтгүүл”, “Монголын долоон өдрийн сэтгүүл”-ийг тус тус эрхэлж, Монгол утга соёлын хүрээ 1939 онд “Утга соёлын тусгай дармалал” хэмээх сэтгүүлийг гаргаж, үүнийг 1940 онд “Монголын утга соёлын дармалал” гэж нэрийг нь сольжээ. Монголын утга соёлын хурал 1940 онд “Дахин мандсан Монголын чимээ”, Ниппонд сургаал хийсэн хамт нөхдийн хурал 1945 онд “Мандах Монгол” хэмээх сэтгүүл тус тус эрхэлж байсан юм. Монголын хязгаарын засгийн эдгээр сонин сэтгүүлүүд нь Монголоо дахин мандуулах, Зүүн Азийн хамт цэнгэлдэх хүрээлэнгээ байгуулах, мөн ардын ухаан мэдлэгийг дээшлүүлэх зорилт тавьж байв.

Японыг эсэргүүцэх дайнд ялалт байгуулсны дараа Дундад улсын Эвхамт намын удирдлагыг хүлээсэн Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөний холбоо нийлэлдсэн хурал ба

түүний салбар хурал 1946 онд “Дотоод Монголын гарагийн сэтгүүл”, “Олон түмэн” (энэ сонин 1947 онд “Уутнамт дотоод монгол” гэж нэрээ сольж, 1948 онд дахин “Өвөр Монголын өдрийн сонин” гэж өөрчилжээ), “Хөлөн буйр” сониныг эрхлэн хэвлэжээ. Дундад улсын Эвхамт намын газар орон дахь ажлын хороо 1944-1948 он болтол “Их зуугийн чуулганы сэтгүүл”, “Урагш чармаа”, “Саруул талын зам”, “Олон түмэн”, “Малчин тариачин сонин” зэрэг сонинуудыг гаргаж байжээ. Дундад улсын Эвхамт намын эдгээр сонин сэтгүүл нь Нанжины засгийн газрын тэрслүү мөн чанарыг элчлэх, Дундад улсын Эвхамт намын эл зүйлийн төрийн бодлогыг ухуулах, Өвөр Монголын эл үндэстний ард түмэнтэй хамтарч шинэ Өвөр Монголыг бүтээн байгуулахаар зорилт болгож байв.

Үүнээс гадна дотоод Монголын Ардын хувьсгалт намын зүүн Монголын хороо ба дотоод Монголын ардын хувьсгалт намын удирдлагыг хүлээсэн дотоод Монголын ардын хувьсгалт залуучуудын эвлэл 1945 онд тус тус “Ардын зам”, “Өглөө” хэмээх тосон дармалын сониныг эрхэлж, дотоод Монголын ард түмний хувьсгалт тэмцэлд оролцохыг уриалж дотоод Монголын Ардын хувьсгалт намын удирдлагаар үндэстний тусгаар тогтнол ба хөгжлийг тэмцэн олох зэрэгт

залуучуудыг жолоодон хамтран тэмцүүлж үндэстний эрх чөлөө, чөлөөлт ба тусгаар тогтнолын биелүүлэхээр зорилт болгож байв. Чанчүнд суугаа Зөвлөлтийн улаан цэрэг 1945 онд “Монгол ард” (энэ төд удалгүй “Ардын сонин” хэмээн нэрээ сольсон) сонин эрхэлж Зөвлөлтийн улаан цэргийг магтах ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг танилцуулах, монголчууд хамтран үндэстний чөлөөг тэмцэн олохыг уриалж байжээ.

2. Орчин үеийн дундад улсын монгол сонин сэтгүүлийн агуулгын онцлог

Орчин үеийн Дундад улсын монгол сонин сэтгүүлийг улс үндэстний доройтон мөхөх аюул түгшүүрт түүхэн ахуй байдалд эл зүйлийн улс төрийн хүчин Монгол орныг булаалдах улс төрийн үзэлтэйгээ ухуулах, өөрийн ашиг тусаа хамгаалах, Монголын нийгмийн асуудлыг ярилцах, монгол үндэстнээ мандуулах яриа хэлэлцээн багжийн хувиар эрхэлсэн болохоор улс төрийн өгүүллийн сонин сэтгүүл бол орчин үеийн Дундад улсын монгол сонин сэтгүүлийн гол урсгал болно. Асуудлыг дэлгэн нягтлахын төлөө нөлөө ихтэй төлөөлөгчтэй сонин сэтгүүлүүдийн үндсэн зорилтийг урьдаар үзье.

| Сонин сэтгүүл | Үндсэн зорилт |
|----------------------|---|
| Нялх сэтгүүл | Ардын мэдлэгийг нээн, шинэ засгийг судлах |
| Монгол үгийн бодорол | Монгол ардын ухаан мэдлэгийг «дэлгэрүүлэх», монголчуудыг «дотогш хандуулах» |
| Монголын сонин бичиг | Хаант Оросын «Алс дорнодын бодлого»-ийг идэвхжүүлэх |
| Сонин бичиг | «Хамт найралдах» үзлийг ухааруулж, монголчуудыг «дотогш хандуулах» |

| | |
|--|---|
| Ихэд нийтлэх монгол бичгийн сэтгүүл | «Хамт найралдах» үзлийг ухааруулж, монголчуудыг «дотогш хандуулах» |
| Монгол ер үгийн сэтгүүл | Монгол ардын ухаан мэдлэгийг нэвтрүүлж, «таван угсаа хамт найралдах» үзлийг ухааруулах |
| Шинэ толь хэмээх бичиг | Монголчуудыг элдэв эрдэмд боловсорч, яаравчлан хүчтэй чийрэг болгох |
| Шо Фаны өдрийн сэтгүүл | Засаг яамны хууль цаазыг ухуулж ар монголчуудыг илбэх буюу сүрдүүлж байгаад Иргэн улсад дагуулах |
| Мүгдэний монгол сэтгүүл | Японы Манж-Монголын тухай бодлогыг идэвхжүүлэх |
| Монгол үсгийн нэгэн эргэлтийн хэвлэл | Монголчуудын үндэстний ухамсрыг арилгаж, улс гүрний үзлийг бий болгох |
| Дотоод Монголын ардын сэтгүүл | Монгол ардын ашиг тусыг хамгаалах, төөрөлдлийг арилгах, эрх чөлөө, эрдэм соёлыг бадруулах |
| Монгол-Төвдийн долоон өдрийн сэтгүүл | Ардын гурван зорилтыг ухуулан монгол-төвд угсаатан бол Дундадын үндэстэн гэдгийг таниулах |
| Монгол-Төвдийн сарын сэтгүүл | Засгийн газрын өршөөлт засаглалыг ухуулж монгол-төвд үндэстний улс гэрийн үзлийг бий болгох |
| Монгол-Төвдийн арван өдрийн сэтгүүл | Ардын гурван зорилтыг ухуулан монгол-төвд угсаатан бол Дундадын үндэстэн гэдгийг таниулах |
| Монгол утгын долоон өдрийн дармал | Ардын гурван зорилтыг сурталчлан засгийн яамны цааз зарлигийг тархаах |
| Монголын арван өдөр тутмын өдрийн дармал | Улсын ардын намын зорилт, засгийн хэлхээ ба төв дундадын цааз зарлигыг Монгол газар дэлгэрүүлэх |
| Жүн Ян Биенбо | Ардын гурван зорилтыг бадруулан засгийн газрын бодлогыг ухуулах |
| Ард олны өдрийн сэтгүүл | Ардын гурван зорилтыг ухуулан Японыг эсэргүүцэхийг сурталчлах |
| Алшаан хошууны түгэм сэтгүүл | Ардын гурван зорилтыг дэлгэрүүлэн төв засгийн хууль зарлигыг ухуулах |
| Монгол | Унтсан монголоо дуудан сэрээж эрх хүчит, өн бат жаргалын хүрээлэн байгуулах |
| Ирээдүйн Монгол | Ард угсаагийн санаа ухааныг төрүүлэн бүгдээр нэгдэж бүх Монголын төлөө чармайх |
| Эх орон | Монголын асуудлыг ярилцах, монгол угсаагаа авран мандуулах |
| Манхын хонх | Монгол ардын эрдэм сургаалыг дэлгэрүүлэн ухаан мэдлэгийг нээгдүүлэн, утга соёлыг урагш давшуулах |
| Шинэ Монгол | Японы шинэ соёлыг Монголд удирдан оруулж Монголын эрдэм соёлыг хөгжүүлэн дэлгэрүүлэх |
| Монгол хошуунд тархаах арван өдрийн дармал | Таван угсааг нэгэн гэр болгож хамт санаагаар харилцан туслалцан ихэд нийцүүлэх дор шаардана давшуулах |
| Зах хязгаарын чимээ нэвтрүүлэх сэтгүүл | Ардын гурван зорилтыг ухуулан монгол ардыг Японыг эсэргүүцэх дайнд дайчлах |
| Монгол утгийн долоон өдрийн сэтгүүл | Намын зорилтыг дэлгэрүүлэн ардын засгийг ухуулан монгол ардыг дотогш хандуулах |

| | |
|--|--|
| Сүй Ен Монгол үсгийн хагас сарын дармал | Таван угсаа эрх тэгшийг ухуулан Дундадын үндэстэн гэдгийг ухуулах, засаг бодлогыг хөгжүүлэх |
| Хянган ерөнхий балгадын хураангуй дармал | Манж улсын засгийн зарлигыг уламжлах, хянган ерөнхий балгадын ажлыг жолоодох |
| Монгол сэтгүүл | Монгол ардыг ухамсаруулан үндэстнээ сэргээн мандуулах |
| Хөх туг | Энэ монгол ардын ухаан мэдлэгийг нэмэгдүүлэх, улсын доторх засаг засалт хийгээд аж ахуйн байдлыг ойлгуулах |
| Улаан бар | Монгол үндэстний оюун бэлгийг нээгдүүлэн монгол угсаатны утга соёлыг боловсруулан хөгжүүлэх |
| Засгийн ордны агуу чимээ | Монголын хязгаарын засгийн хууль зарлигыг уламжлах |
| Монголын долоон өдрийн сэтгүүл | Монголоо дахин мандуулах, Зүүн Азийн хамт хөгжих хүрээлэн байгуулах |
| Утга соёлын тусгай дармал | Монголчуудын төрөлхийн соёлыг хөгжүүлж шинэ соёлыг шингээн авах |
| Дахин мандсан Монголын чимээ | Утга соёлыг дэлгэрүүлэх, дахин мандсан Монголын хэрэгт тус болох |
| Мандах Монгол | Эх Монголын эрдэм соёлын хөгжилд хувь нэмэр үзүүлэх |
| Дотоод Монголын гарагийн сэтгүүл | Эвхамт намын эл зүйлийн төрийн бодлогыг ухааруулах, бүх улсыг чөлөөлөхөд туслах |
| Олон түмэн «Вангийн сүм» | Олон түмний улс төр, аж ахуй, соёл боловсролын аливаа биеийн хөрвүүлэх тэмцлийн хөдөлгөөн удирдах |
| Дотоод Монгол | Хянган мужын засгийн ордны хууль зарлиг ба хувьсгалын тухай ухуулах |
| Эрх чөлөө | Гоминданы хятадчилах үзлийг эсэргүүцэх, ардчилсан хувьсгалыг биелүүлэх |
| Өвөр Монголын өдрийн сонин | Ард түмний улс төрийн ухамсар ба соёлын хэр хэмжээг дээшлүүлэх |
| Ардын зам | Монгол үндэстний тусгаар тогтнол, эрх чөлөө ба хөгжлийг тэмцэн олох |
| Монгол ард | Зөвлөлтийн улаан цэргийг магтах, Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг танилцуулах |

Дээрх хүснэгтээс үзэхэд орчин үеийн Дундад улсын монгол сонин сэтгүүлүүдийн үндсэн зорилт нь ерөнхийдөө монгол ардын ухаан мэдлэгийг нээгдүүлэх, улс гүрний үзлийг ухуулах, хамт найралдахыг ухуулах, ардын гурван зорилтыг уламжлах, засгийн газрын засаг засалтыг ухуулах, утга соёлоо хөгжүүлэх, Монголоо мандуулах, тусгаар тогтнол, эрх чөлөөгөө тэмцэн олох, эв хамт ёсыг ухуулах, Зүүн Азийн хамт хөгжилдөх хүрээлэнг байгуулах, хаант Оросын Алс дорн-дын бодлого ба Япон улсын Манж-Го Монголын тухай бодлогыг идэвхжүүлэх

гэх хэдэн зүйлд төрөлжүүлж болно. Орчин үеийн Дундад улсын монгол сонин сэтгүүлүүд нь дээрх үндсэн зорилтын эргэн тойронд асуудлыг дэлгэн хөгжүүлж яриа хэлэлцээр зохиож байсан юм. Тэдгээр монгол сэтгүүл нь улс төрийн өгүүллийн сонин сэтгүүл болсны хувьд бусад сонин сэтгүүлээс ялгагдах доорх хэдэн талын хэв, хэлбэр онцлогтой.

1. Шүүмж өгүүллийн онцлогтой. Энэ нь орчин үеийн монгол сонин сэтгүүл эл зүйлийн улс төрийн хүчин, Монгол орныг булаалдах, Монгол оронд явуулах засаг бодлогоо найдваржуулах,

Монгол орон дахь арилжаа худалдааны ашиг тусаа хамгаалах, Монголын асуудлыг ярилцах ба Монголоо мандуулах зэргийн маш тодорхой зорилгоор эрэмбэлэгдсэн байдаг. Иймээс энэ цаг үеийн монгол сонин сэтгүүлүүд агуулгын хувьд энэ их зорилгоо биелүүлэхийн төлөө дээрх асуудлуудын тухай шүүмжлэн өгүүлэх чухал баримт тавьж, агуулга ба хэлбэрийн хувьд улс төрийн өгүүлэл шүүмжээр гол болгодог. Энэ нь монгол сонин сэтгүүлийг багтаасан Дундад улсын сонин мэдээллийн үйлсийн уламжлал буюу онцлог болж бүрэлдсэн байдаг.

2. Сонин сэтгүүлийг агуулгын хувьд үзвэл хэдийгээр улс төрийн шүүмж өгүүллийг чухалчилдаг боловч сонин мэдээллийн харин үл гадуурхан зохих хэмжээнээ хүндэтгэн үздэг байсан. Тэрчлэн цөөн хэдэн сонин сэтгүүлийн мэдээний хувийн жин харьцангуй их шиг байх үзэгдэл ч буй. Гэвч энэ нь сонин сэтгүүл эрхлэгчдийн үндсэн зорилт биш. Харин уншигчид мэдээ занги хангахаар дамжуулан түүний сонин сэтгүүлийн суртал ухуулагдаа үйлчлүүлсэн байдаг.

3. Орчин үеийн Дундад улсын монгол сонин сэтгүүл улс төрийн өгүүллийн сонин сэтгүүл болсны хувьд зар сурталчилгааг дэмий чухалчилдаггүй байсан юм. Тус цаг үеийн монгол сонин сэтгүүлийн цөөвтөр хэдэд нь хаяа нэг зар нийтлэгддэг байсныг гаргавал бусад олонх сонин сэтгүүл дээр зар бараг харагддаггүй юм. Учир нь улс төрийн өгүүллийн сонин сэтгүүлийг сонин сэтгүүл эрхлэгчид өөрийн үзэл санааг ухуулах, яриа

хэлэлцээр зохиох тодорхой зорилгоор эрхэлдэг болохоор цөм тус тусынхаа дармал эрхлэх үндсэн зорилттой байж гол хүчээ улс төрийн ухуулга дээр тавиад ашиг орлогыг дэмий хөөцөлдөггүй юм.

4. Орчин үеийн Дундад улсын монгол сонин сэтгүүл цөм улс төрийн тодорхой зорилгоор эрхлэгдсэн болохоор яриа хэлэлцээр зохиох, суртал ухуулгыг голчлон анхаарч, уншигчдын дур сонирхол хэрэгцээ шаардлага ба хүлээн авах чадварыг дэмий хамаардаггүй юм. Зарим сонин сэтгүүлд хэдийгээр уншигчдын дур сонирхол, хэрэгцээ ба хүлээн авах чадварыг зохих хэмжээгээр бодолхийлсон байх боловч «Жишээлбэл зохих сонин мэдээлэл нийтлэх эргээд дөхөм ойлгомжтой ёгт үлгэр, хошин шог зураг зэрэг ухуулгын зургыг гаргах, сонин сэтгүүлийн нүүр хуудсаа чимэх зэрэг» энэ нь нэн сайн хийхэд зориулагдсан байдаг юм.

5. Орчин үеийн Дундад улсын монгол сонин сэтгүүл нь улс төрийн өгүүллийн сонин сэтгүүл болсны хувьд:

- Сонин сэтгүүл эрхлэгчид өөрийн үзэл санаа, байр сууриа уламжлах, ард иргэдийн ухаан мэдлэгийг нээх, үзэл санаагаа чөлөөлөхийг чухалчилдгаас ард иргэдийн соён гэгээрүүлэх яриа хэлэлцээр зохиох буюу нөлөөлөх үйлдэлтэй байдаг.

- Улс төрийн өгүүллийн сонин нь суртал ухуулгыг өрнүүлэн яриа хэлэлцээр зохиох онцлог нь сүүлийн үеийн намын сонин намч чанарыг онцлогийг бүрэлдүүлэхэд суурь тавьсан юм. Энэ бол орчин үеийн Дундад улсын монгол сонин сэтгүүлийг багтаасан улс төрийн өгүүллийн сонин

сэтгүүлийн хэвлэл мэдээллийн түүхэн дэх байр суурь болон хойшдын хэвлэл мэдээллийн үйлсэд үзүүлсэн нөлөө болно.

Төгсгөл

1. Орчин үеийн Дундад улсын монгол сонин сэтгүүлүүдийн эл зүйлийн улс төрийн хүчин, Монгол орныг булаалдах, Монголын асуудлыг ярилцах суртал ухуулгын багжийн хувиар эрхэлсэн учраас албанаас эрхэлсэн болон албаны дэмжлэгтэй хурал бүлгэмийн эрхэлсэн сонин сэтгүүл гол байрыг эзэлж, монголчуудын өөрийн эрхэлсэн сонин сэтгүүл харин харьцангуй цөөн тоог эзэлж буй. Энэ нь тухайн цаг үед монголчууд улс төрийн талаар бие даасан эрхгүй, аж ахуйгаар хоцронгуй ядуу болохоор монголчуудын өөрийн эрхэлсэн сонин сэтгүүлүүд тоотой хэдхэн байсан бөгөөд хэвлэл үргэлжилсэн цаг хугацаа ч ахархан байсан юм.

2. Орчин үеийн Дундад улсын монгол хэвлэлийн дотор сэтгүүл нь харцангуйгаар сониноос олон байгаа юм. Дундад улсын монгол орны нутаг дэвсгэр өргөн уудам, хүн амын суурьшил тархай бутархай бөгөөд тухайн үеийн монгол орны зам харилцаа шуудан холбооны үйлсийг дотор газартай харьцуулвал маш хоцронгуй буйд бөглүү байсан юм. Ийм байдалд номын хэлбэрээр дэвтэрлэж үдсэн сэтгүүл нь нүүр хуудсаар олон үелэх хугацаа харьцангуйгаар урт байдаг учраас сониныг бодвол дөхөм, агуулгын багтаамж их байх нь буйд бөглүү газар орны уншигчдын гарт хүргэхэд нэлээд өдөр хоног хэрэгсдэг байдалтай тохиролцож байдаг юм.

3. Орчин үеийн Дундад улсын Монголын нийгэм бол эрээн бараантай бөгөөд дайн дажин ихтэй байсан цаг үе болохоор монгол сонин сэтгүүлүүд цаг үеийн үймээн дүйжээнээс болоод урт хугацаанд үргэлжилж чадсангүй. Тэрчлэн зарим сонин сэтгүүлийн нэг буюу хэдхэн дугаар гараад хэвлэл нь зогсон ер нь ахар байсан юм.

4. Тухайн үеийн монгол сонин сэтгүүлийн дотор монгол, хятад хавсарсан хэвлэл бараг бүх сонин сэтгүүлийн хагас илүү тоог эзэлж буй. Үүнд оросууд болон япончуудын эрхэлсэн сонин сэтгүүл Манж-Го улс ба Монголын хязгаарын засгийн хараанд байсан зарим сонин сэтгүүлүүд цул бүгд монгол хэвлэл байсныг гаргавал Дундад улсын албанаас эрхэлсэн буюу албаны дэмжлэгтэй хурал нийгэмлэгийн сонин сэтгүүлүүдийн олонх нь цөм хятад, монгол харьцуулсан хэвлэл юм. Энэ нь Дундад улсын засгийн газрын эзэрхийлэл буюу засгийн газрын цөөн тоот үндэстний хятадад уусгах гэсэн төрийн бодлогын шаардлагаас болсон юм гэж ойлгож болно.

5. Тухайн үеийн монгол сонин сэтгүүлүүд хорголжин бар, чулуун дармал, тосон дармал гэх гурван зүйлийн бар мэргэжлийг хэрэглэж байсан бөгөөд хэвлэл мэргэжлийн хувьд чулуун дармал нь нэлээд түгээмэл хэрэглэгдэж байжээ. Гэтэл 1945 оноос хойш гарч байсан сонин сэтгүүлүүдийн олонх нь дайны тухай ухуулах, намын хөтөлбөр ба бодлогыг уламжлах бачим яаралтай ухуулгын шаардлагаас болж үелэх хугацаагаар ахар сонины хэлбэрээр гарч байсан бөгөөд өөрийн өртгөөр тосон дармалаар дармаллагдаж

байсан юм. Монгол хорголжин барын хэвлэл харьцангуй цөөн байсны учир бол тухайн цаг үед Дундад улсад монгол хорголжин бар үйлдэгдээд удалгүй түгээмэл болж амжаагүй байсантай холбоотой юм.

Ишлэл

¹ Багана: Монгол үндэстний ойр орчин үеийн сонин үйлсийн анхны шинжлэл. «Өвөр монголын их сургуулийн эрдэм шижилгээний сэтгүүл». 2004 оны 6-р дугаар

² 忒莫勒:《内蒙古旧报刊考录》,第七页,远方出版社,2010年

³ Сонин мэдээ хэвлэлийн бодь найруулах комис найруулав. Монгол судлалын нэвтэрхий толь. Сонин мэдээ хэвлэлийн бодь. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

⁴ 忒莫勒:《建国前内蒙古地方报刊考录》,第117页,内蒙古自治区图书馆编。

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. «Уудамт дотоод монгол». 1947.1.1-1947.6.26 (36-61).

2. «Ирээдүйн Монгол». (蒙古前途), 1935 (19, 22-33).

3. «Олон түмэн» (群众), 1946.7.1-1946.8.15 (1-27).

4. «Улаан бар» (丙寅), 1939.1.31-1939.12.30 (5:1-12).

5. «Өөртөө засах Өвөр Монгол» (内蒙古自治报), 1947.7.6-1947.7.27 (62-68).

6. «Өвөр Монголын өдрийн сонин» 1948.1.1-1948.2.24 (1-24)

7. «Өвөр Монголын гарагийн сэтгүүл» (内蒙古周报), 1949.1-1949.4 (1-15).

8. «Бэйпинд байх монгол сурагчын хуралын эхлэн үүсгэсэн дармалал» (蒙古留平学生会创刊号), 1929 (1).

9. «Хянган ерөнхий балгадын хураангуй дармал» (兴安总署汇刊), 1933.4 (1:1).

10. «Хол дахиныг амаржуулсан хотны долоон өдөр бүр дармаллах сэтгүүл» (绥远蒙文周刊), 1925.8.25 (3).

11. «Хөх туг» (青旗), 1941 (1-15, 17-40).

12. «Манхын хонх» (漠声), 1935 (1).

13. «Монгол» (蒙古), 1930 (6).

14. «Монголын арван өдрийн сэтгүүл» (蒙古旬刊), 1930.10.10-1931-10.10 (1-36).

15. «Монголын сонин бичиг», 1909 (3-13, 20).

16. «Монголын дуун» (蒙声), 1947 (5-6).

17. «Монголын өдрийн долоон өдрийн дармал» (蒙古周刊), 1931.10.17-1932.1.23 (37-50).

18. «Монголын өдрийн долоон өдрийн сэтгүүл» (蒙古周刊), 1938 (28).

19. «Монгол утгын сэтгүүл» (蒙文报) 1915 (1-3, 5-9), 1916 (1, 3).

20. «Монгол утгын долоон өдрийн сэтгүүл» (蒙文周报) 1933-1937 (1-165).

21. «Монгол утгын долоон өдрийн дармал» (蒙文周刊) 1931-1933 (1-96).

22. «Монгол үгийн бодрол» (蒙话报), 1908-1910 (1-7, 9-23, 25).

23. «Монгол үсгийн нэгэн эргэлтийн хэвлэл» (蒙文周刊), 1925.10.28 (9).

24. «Монгол үсгийн сэтгүүл» (边疆通信报), 1939.7.15-1940.2.24 (3-15).

25. «Монгол бичгийн сэтгүүл» (边疆通信报), 1939.7.1-1939.7.8 (1-2).

26. «Монгол хошуунд тархаах арван өдрийн дармал» (蒙旗旬刊), 1929 (1-13, 15), 1930 (1-12, 14-20), 1931 (1-16), 1929-1931 (3-).

27. «Монголын газарч» (蒙古向导), 1935 (1, 3, 6, 7).

28. «Монгол-Төвдийн арван өдрийн сэтгүүл» (蒙藏旬刊), (1-11, 23-100, 108, 110-115).

29. «Монгол-Төвдийн арван өдрийн сэтгүүл» (蒙藏旬报), 1931.11-1933.6 (1:1-8:3, 11:1-1-3, 13:1, 14:3).

30. «Монгол-Төвдийн хагас сарын сэтгүүл» (蒙藏半月刊), 1933.7-1933.12 (1:1-8:3, 11:1-1-3, 13:1, 14:3).

31. «Монгол-Төвдийн сарын сэтгүүл» (:1 蒙藏月报), (1:2-6, 2:1-5, 3:3-6, 4:1-6, 5:1-6, 6:1-6, 7:1-7, 11:1-6, 13:1-4, 18:9-12, 19:1-12, 20:1-2, 5-10).

32. «Монгол-Төвдийн долоон өдрийн сэтгүүл» (蒙藏周报), (21, 23-27, 33, 35-37, 40-60, 63-81).
33. «Монгол ер үгийн сэтгүүл» (蒙文白话报), 1913-1914 (1-18).
34. «Мүгдэний монгол сэтгүүл» (奉天蒙文报), 1918 (5-7, 15-16, 56-58, 62, 63).
35. «Шинэ Монгол» (新蒙), 1945 (1:1), 1948 (4:5-8).
36. «Шинэ Монгол» (新蒙古), 1941-1944 (1,3-4).
37. «Сонин бичиг», 1912.8.28 (17).
38. «Сүй Ен Монгол үсгийн хагас сарын дармал» (绥远蒙文半月刊), 1929-1932 (1-60).
39. «Шо Фаны өдрийн сэтгүүл» (朔方日报), 1919-1920 (1, 19-63, 100-103, 111-129, 135-136, 142, 153, 156, 180).
40. «Дахин мандсан Монголын чимээ» (复兴蒙古之声), 1940 (4, 6, 7, 9-15).
41. «Дотоод Монгол» (内蒙古), 1946.7-1946.9 (1-6).
42. «Зах хязгаарын чимээ нэвтрүүлэх сэтгүүл» (边疆通信报), 1940.3.2-1942.3.28 (16-17).
43. Найман муж орны монгол хэл бичгийн ажлын хамжилцах дугуйлангийн албан гэр найруулав. «Бүх улсын монгол хуучин ном бичгийн гарчиг». Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1979.
44. *Мөнгөндалай* Боржигон найруулав. «Бээжингийн номын сангийн монгол хуучин бичгийн товч». Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1989.
45. Монгол судлалын нэвтэрхий толь найруулах зөвлөлөөс найруулав. «Монгол судлалын нэвтэрхий толь сонин мэдээ хэвлэлийн бодь». Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2003.
46. *Дээцэдэв, Ванмандаа*. «Дотоод Монголын ардын сэтгүүлийн ардын сэтгүүлийн гэрэл зургийн буулгуур ариутгал шүүдэг». Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2007.

47. Дундад улсын эртний монгол ном бичгийн ерөнхий гарчгийн найруулах зөвлөл найруулав. «Дундад улсын эртний ном бичгийн ерөнхий гарчиг». Бээжингийн номын сан. 1999.

48. 呼和浩特市民族事务委员会：《民族古籍与蒙古文化》，总第 3-4 期，编辑出版，2003 年。

49. 呼和浩特市民族事务委员会：《民族古籍与蒙古文化》，第九期，编辑出版，2003 年。

50. 忒莫勒编撰：《建国前内蒙古地方报刊考录》，内蒙古图书馆，1987 年。

51. 忒莫勒编著：《内蒙古旧报刊考录》（1905-1949.9），远方出版社，2010 年。

52. 中国人民政治协商会议内蒙古自治区委员会文史资料研究委员会编：《内蒙古文史资料》，第 1-2, 4-7.10, 13-17, 19-20, 23, 29, 31-32, 34-35, 38, 44, 50 辑，内蒙古人民出版社，1962-2001 年。

Резюме

Харчин баруун хошууны Засаг жүн ван Гүнсээноровын 1905 онд эрхэлсэн “Гаргийн албан сэтгүүл” болон “Нялх сэтгүүл” бол Дундад улсын анхны монгол сонин болно. 1905-1949 онд Бүгд Найрамдах Дундад ард улс байгуулагдах хүртэл 44 жилийн хооронд дундад улсын хил дотор нийт 131 монгол сонин сэтгүүл хэвлэгдэж өнгөрчээ. Харамсалтай нь эдгээр сонин сэтгүүлүүдээс бидний үед зөвхөн 87 нь тархай бутархайгаар хадга-лагдаж буй бөгөөд бусад нь хэвлэгдэж байсан мэдээ төдийхнөөр хязгаарлагдаж буй юм. Үүнд орчин үеийн Дундад улсын сонин сэтгүүлүүд засгийн газрын хууль зарлиг, хөтөлбөр ба шийдвэрийг уламжлан дэлгэрүүлэх эл зүйлийн улс төрийн хүчний ашиг тусыг хамгаалахад яриа хэлэлцээр зохиохоос гадна монголчуудад шинэ мэдлэг уламжлан тэдний соёон гэгээрүүлэхэд зохих үүрэг гүйцэтгэсэн юм.